



Äóí äā äü àéì äадахь Төрийн аоäèòü í ääçàð

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН
ҮАГ-НАГ/2017/03-НА**

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛЭН ЗАХИРАГЧ | ЯАМ | АГЕНТЛАГ | ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙ НЭГЖ | ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР | АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛАГА, ИРГЭН

ШИЛЭН ДАНС

Эхлэл | Орон нутаг | Мэдээ мэдээлэл | Холбоо барих | Нэвтрэх

Дундговь

Улаанбаатар	Баян-өлгий	Баянхонгор	Булган	Товь-алтай	Архангай
Говьсүмбэр	Дархан-уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Хэнтий
Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Хөвсгөл
Сэлэнгэ	Төв	Увс	Ховд		

Сайнцагаан сум
Адаацаг сум
Банжаргалан сум
Говь-Угтаал сум
Гурвансайхан сум
Дэлгэрхангай сум
Дэлгэрцогт сум
Дэрсэн сум
Луус сум

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ì áí ääèèä üü

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	5-6
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	БҮЛЭГ 1 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагуудаас бусад байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан ажилласан байна.	7-9
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд хамрагдаагүй байна.	7-8
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.2 Сумдын байгууллагууд өөрийн цахим хуудсаар шилэн дансны мэдээллийг мэдээлээгүй байна.	8-9
Аудитор Т.Оюун-Эрдэнэ	БҮЛЭГ 2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудаас шилэн дансны цахим хуудастай байгууллагууд мэдээллийг 92.4 хувьтай мэдээлсэн байна.	9-11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны мэдээллийг 96.3 хувьтай мэдээлснээс 11 хувийг хугацаа хоцорч мэдээлжээ.	9-10
	2.2 Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 болон 3.1.2 –т хамаарах байгууллагууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 89.4 хувьтай мэдээлснээс 11.9 хувийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	10
	2.5 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5-т хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй байна.	11
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү.	БҮЛЭГ 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон иргэдийн хяналт хангалтгүй байна.	11-13
www.audit.mn	3.1 Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	11
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	3.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ТЕЗ-ийн харьяаны 151 байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийжээ.	12
	3.3 Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээс төсвийн байгууллагуудад хяналт шалгалт хийхдээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.	12
2017 оны 11 дүгээр сар		

3.4 Шилэн дансны мэдээллийг иргэд ашигладаггүй, хяналт тавьдаггүй байна.	12-13
БҮЛЭГ 4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	13-14
4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлжээ.	13-14
4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	14
Дүгнэлт	15
Зөвлөмж	15
Дээд шатны байгууллагад хүргэх санал	16
Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар	17
Тайлан баталгаажуулах тушаал	18
Тайлангийн хавсралтууд	19-27

ТОВЧИЛСОН ҮГС

ҮАГ	Үндэсний аудитын газар
НА	Нийцлийн аудит
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
УТБ	Улсын төсвийн байгууллага
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ИТХ	иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БЦГЗ	Байгалийн цогцолбор газрын захиргаа
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ЗДТГ	Засаг даргын Тамгын газрын дарга
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
БТСХ	Биеийн тамир спортын хороо
СЦ	Сайнцагаан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 19.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх;
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын асуудлын шинжилгээнд орсон орон нутагт хамааралгүй дараах асуудлуудыг тайланд тусгаагүй болно. Үүнд:

- 🚩 2 дугаар бүлгийн 2.3;
- 🚩 2 дугаар бүлгийн 2.4.

Аудитын хамарсан хүрээ: Дундговь аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу хамрагдвал зохих нийт 254 байгууллагаас 179 байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Аудитад ТЕЗ-ийн 16, улсын болон орон нутгийн төсвийн 140, ЗГТС 3, ТӨҮГ 2, ОНӨААТҮГ 18 нийт 179 байгууллагын 2016 оны 4 дүгээр улирал, 2017 оны эхний 3 дугаар улирлын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулсан мэдээлэл, батлагдсан төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээнүүд, НББ-ийн журнал, холбогдох баримтыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй, горим: Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Нийцлийн аудитын түр журмыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа хийх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд харьцуулалт, нөхцөл байдлын шинжилгээ хийх;
- Аудитад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах;
- Иргэдээс санал асуулга авч нэгтгэх.

Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглааа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 01 сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудитын хугацаа, агаар өдөр: Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл, хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Т.Оюун-Эрдэнэ нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн: Аудитаар нийт 15,285.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 735.8 сая төгрөгийн хугацаатай албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад, 14,549.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах тухай зөвлөмжийг ТЕЗ-д хүргүүлсэн.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Шилэн дансны тухай хуулийг баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлсэн.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор анх баталж, шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулж эхэлсэн. 2016 оны эхээр шилэн дансны цахим сайт шинэчлэгдэн өмнөх журмыг хүчингүй болгож, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2016 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг хийж, аудитаар 31.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 2 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлж байжээ.

БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагуудаас бусад байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан ажилласан байна.

1.1 Хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансанд хамрагдаагүй байна.

Дундговь аймгийн хэмжээд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1¹–дүгээр заалтад хамаарах 254 байгууллага байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хуулийн заалт	ОНТБ		УТБ		ОНӨААТҮ Г	ТӨҮГ	Нөхөрлөл	ААНБ	Нийт
	ТӨЗ	ТШЗ	ТШЗ	ЗГТС					
3.1.1. ²	16	114	25	3	18				176
3.1.2. ³						8			8
3.1.3. ⁴									0
3.1.4. ⁵								35	35
3.1.5. ⁶							2	33	35
Нийт	16	114	25	3	18	8	2	68	254

Тус хуулийн 3.1.1 болон 3.1.2 дахь заалтад хамаарах нийт 184 байгууллагаас 177 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 /Төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий

¹ 3.1. Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

² 3.1.1. төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

³ 3.1.2. төрийн өмчит үйлдвэрийн газар;

⁴ 3.1.3. хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

⁵ 3.1.4. улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

⁶ 3.1.5. төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй/ -д заасны дагуу Тагнуулын ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь хэлтэс шилэн дансанд бүртгэлгүй байна.

Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа 8 ТӨҮГ-аас Зам тээврийн яамны харьяа Нисэх буудал, Авто тээврийн үндэсний төвүүд нь шилэн дансны цахим хуудастай, бусад ТӨҮГ-уудын шилэн дансыг төв компани нь өөрийн шилэн дансны цахим хуудсанд нэгтгэн мэдээлжээ.

Орон нутагт салбартай төрийн өмчит үйлдвэрийн газар болон хувьцаат компаниуд нь шилэн дансны цахим хуудсанд салбар байгууллага тус бүрээр эсвэл нэгтгэж мэдээлэх эсэх талаар Шилэн дансны тухай хуулинд тодорхой заагаагүй. Энэ асуудлыг цаашид журмаар зохицуулан тодорхой болгох талаар өмнөх аудитаар ҮАГ-т санал хүргүүлсэн боловч тодорхойгүй байдал хэвээр байна.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.4 болон 3.1.5 дахь заалтад хамаарах 70 ААНБ байгаа боловч 2 өрхийн эмнэлгээс бусад ААНБ шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ оруулаагүй байна.

Байгууллагын бүтэц өөрчлөгдөн татан буугдсан Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Улсын нөөцийн салбар, давхардуулан нээлгэсэн ГХБХБГ, Адаацаг сумын ЭЭС зэрэг байгууллагуудын шилэн дансны цахим хуудсыг хасах шаардлагатай байна.

1.2 Сумдын төсвийн байгууллагууд өөрийн цахим хуудсаар шилэн дансны мэдээллийг мэдээлээгүй байна.

Аймгийн **Dundgovi.gov.mn** цахим хуудсанд төсвийн байгууллагуудын цахим хаяг байрладаг бөгөөд шилэн дансны бие даасан цэстэй, цэсээр ороход **Shilendans.gov.mn** нэгдсэн цахим хуудсанд холбогдож, тухайн байгууллагын шилэн дансны мэдээлэл гарч ирнэ.

Харин Говь-Угтаал, Өндөршил сумдаас бусад сумдын шилэн дансны холбоос хоосон, мэдээлэл байхгүй байна.

Байгууллагууд тодруулга өгөх албан тушаалтны нэр, холбоо барих утсыг оруулсан боловч солигдсон тохиолдолд мэдээллийг шинэчлээгүй зөрчил нийтлэг илэрч байна.

Цахим хуудсанд байршуулсан маягтаарх мэдээллийг татаж авах, хэвлэх боломжгүй байна. Үүнийг цаашид засаж сайжруулах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.4.1 /Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт/ дэх заалтыг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.3 /тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 1, 20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар/ -дахь маягтаар мэдээлнэ гэж заажээ.

Тус журмын 20 дугаар хавсралт нь Шилэн дансны тухай хуулийн 6.2.6, 6.3.2, 6.3.3, 6.3.8 дахь заалтын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээлэх хүснэгт бөгөөд дээрх маягтаас төсвийн өөрчлөлтийг харах боломжгүй байна. Иймд тус маягтыг мэдээллийн агуулгын дагуу засч сайжруулах саналтай байна.


Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8⁷-д заасны дагуу төсвийн байгууллагууд шилэн дансны мэдээллийн самбарыг ашиглан олон нийтэд мэдээллийг хүргэж байна.

Зарим байгууллагуудын хувьд шилэн дансны самбарыг нягтлан бодогчийн өрөөнд байрлуулсан, мэдээллийг шинэчлээгүй зэрэг зөрчил илэрснийг аудитын явцад зөвлөмж өгч ажилласан.

БҮЛЭГ 2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудаас шилэн дансны цахим хуудастай байгууллагууд мэдээллийг 92.4 хувьтай мэдээлсэн байна.

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд нь шилэн дансны мэдээллийг 96.3 хувьтай мэдээлснээс 11 хувийг хугацаа хоцорч мэдээлжээ.

Аудитад хамрагдсан 179 байгууллагын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1 /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ/ -д заасны дагуу тогтмол мэдээлэх нийт 15 төрлийн 11116 мэдээллийн 4 хувь буюу 406 мэдээг мэдээлээгүй, 11 хувь буюу 1192 мэдээг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Үүнийг графикаар харуулбал:



Тогтмол мэдээлэх мэдээллүүдийг заалт тус бүрээр нь хэрхэн мэдээлсэн байдлыг хавсралт №1, хугацаа хоцорсон байгууллагуудын жагсаалтыг хавсралт №3-аар тус тус харууллаа.

Аудитын явцад дараах зөрчлүүд илэрч, холбогдох тушаалтнуудад албан шаардлагыг хүргүүллээ. Үүнд:

- Луус сумын боловсролын байгууллагууд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хоосон хадгалж 398.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,
- Сайхан-Овоо сумын ЭЭС нь 2017 оны 10 дугаар сард шинээр шилэн дансны цахим хуудас нээлгэсэн боловч мэдээллээ оруулаагүй байна.

Аудитаар нийтлэг илэрсэн зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй ажиллах тухай зөвлөмжийг ТЕЗ-д хүргүүлсэн. Үүнд:

- Аудитын тайлан, дүгнэлтийг мэдээлээгүй 156 байгууллага;
- Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлээгүй 4 байгууллага;
- Батлагдсан төсвийг мэдээлээгүй 29 байгууллага;
- Дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй 35 байгууллага;

⁷ 5.8.Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

- Санхүүгийн тайлан мэдээлээгүй 18 байгууллага;
- Улирал бүр мэдээлэх хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг мэдээлээгүй 101 байгууллага;
- Худалдан авах ажиллагааны тайлан мэдээлээгүй 7 байгууллага.

2.2 Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 болон 3.1.2-т хамаарах байгууллагууд 7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 89.4 хувьтай мэдээлснээс 11.9 хувийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.



Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ/-д заасны дагуу нийт 8 төрлийн 14720 мэдээллийн 11 хувь буюу 1567 мэдээллийг мэдээлээгүй байна.

Үүнийг графикаар харуулбал:

Долоо хоногийн дотор мэдээлэх мэдээллүүдийн заалт тус бүрээр нь хэрхэн мэдээлсэн байдлыг хавсралт №2, хугацаа хоцорсон

байгууллагуудын жагсаалтыг хавсралт №3-аар тус тус харууллаа.

Аудитын явцад 7 хоногийн дотор мэдээлэх мэдээлэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрч, холбогдох албан тушаалтнуудад албан шаардлагыг хүргүүлжээ. Үүнд:

- ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд 50 тендер төлөвлөгдсөнөөс эхний 3 улирлын байдлаар 31 тендер зарлагдаж нийт 87 компани оролцож материалаа ирүүлснээс 35 компани шалгарсан боловч шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг оруулаагүй байна. *Үй үй Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь /тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан/ заалтыг;*
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг шалгах явцад Засаг даргын хөрөнгө зарцуулах тухай захирамжаар 337.7 сая төгрөгийг зарцуулах 12 шийдвэр гарсан боловч мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.4.8 /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр/ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Өмнөх онуудад Төрийн аудитын газраас 3 удаа, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 1 удаа Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийгдсэн боловч зөрчил давтагдсаар байгаа нь удирдлага болон нягтлан бодогч нарын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна. Иймд ТЕЗ ажлын хариуцлага алдсан албан тушаалтнуудад арга хэмжээ авч, зөрчлийг давтан гаргуулахгүй ажиллах шаардлагатай байна.

2.5 Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй байна.

Тус онд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.4 болон 3.1.5 дахь заалтад хамаарах нийт 72 ААНБ үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Тус оны эхний 3 улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 дэх /улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;/ заалтад хамаарах 2,604.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 тендерт шалгарсан 35 аж ахуйн нэгж, байгууллага;
- Малын вакцины тарилгын үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж 2016 оны 4 дүгээр улиралд 236.5 сая төгрөгийн, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 225.4 сая төгрөгийн санхүүжилт авсан сумдын 32 мал эмнэлэг;
- Орон нутгийн төсвөөс санхүүждэг 2 нөхөрлөл /өрхийн эмнэлэг/;
- 2017 оны 3 улирлын байдлаар орон нутгийн төсвөөс 23.2 сая төгрөгийн дэмжлэг авсан Ахмадын хороо.

Нөхөрлөл буюу 2 өрхийн эмнэлгээс бусад байгууллагууд шилэн дансны цахим хуудас нээлгээгүй, мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь санхүүжилт олгогч байгууллагуудын хяналт муу байгаагаас шалтгаалж байна.

Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу мэдээллийг оруулах талаар гэрээнд тусгаж, гэрээг дүгнэхдээ мэдээлэл оруулсан байдалд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон иргэдийн хяналт хангалтгүй байна.

3.1 Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 /Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ/ дэх заалтын дагуу Төрийн аудитын газар 2017 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ тухай 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/137 дугаар албан бичгээр мэдэгдсэн.

Өмнөх аудитаар “Аймаг, сумын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал хуулинд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах” талаар зөвлөмж өгч ажилласан боловч тус зөвлөмж хэрэгжээгүй байна. Иймд зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

3.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ТЕЗ-ийн харьяаны 151 байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийжээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймгийн ТЕЗ-ийн харьяаны 151 байгууллагын 2016 оны шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна. Аудитаар 2,183.0 сая төгрөгийн мэдээллийг сүлжээнд байршуулаагүй зөрчлийг илрүүлжээ.

Дотоод аудитын хорооны “Шилэн дансны цахим сүлжээнд байршуулсан мэдээлэлд хийсэн шалгалтын дүнгийн тухай” 1 дүгээр тогтоолоор шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

Мөн тус хуулийг удаа дараа зөрчиж, үүргээ хангалтгүй биелүүлсэн төсөв захирагч нарт сахилгын арга хэмжээ авчээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн 2016 оны хэрэгжилтэд 2017 оны 1 дүгээр сард аудитыг хийж гүйцэтгэсэн нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж чадаагүй байна. Дотоод аудитыг тайлант хугацаанд нь хийвэл үр дүнтэй болохоор байна.

3.3 Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээс төсвийн байгууллагуудад хяналт шалгалт хийхдээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй байна.

Аймгийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн холбогдох албан тушаалтантай уулзалт хийхэд байгууллагуудын 2016 оны үйл ажиллагааг дүгнэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгайлан шалгадаггүй, бусад үйл ажиллагаа хэсэгт оруулан дүгнэдэг байсан тухай мэдээллээ.

Тус хэлтэс 2017 онд Дундговь аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журмыг боловсруулан, батлуулах шатандаа явж байгаа бөгөөд тус журмын төслийн 4.1.12-т /Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтад өгсөн үнэлгээ/ гэж заан тусад нь шалгуур болгон үнэлэхээр болсон байна.

3.4 Шилэн дансны мэдээллийг иргэд ашигладаггүй, хяналт тавьдаггүй байна.


Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, иргэдийн хяналтын талаар нэг зуун тавин иргэнээс дараах 5 асуудлаар санал асуулгыг авч нэгтгэлээ. Үүнд:

№	Асуулт	Хариулт		
		Хангалттай	Дунд	Огт мэдэхгүй
1	Шилэн дансны тухай хууль болон хэрэгжилтийн талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?	28	54	68
№	Асуулт	Тийм	Үгүй	
2	Шилэн дансны Shilendans.gov.mn сайтаар зочлон мэдээлэл авч байсан уу?	36	114	-
3	Шилэн дансан дахь мэдээллийг авч ашиглаж байсан уу?	33	117	-

4	Тус хуулинд заасан иргэний хяналтын талаар мэддэг үү?	33	117	-
5	Иргэний үүргээ биелүүлж хяналтыг хийж байсан уу?	18	132	-

Шилэн дансны тухай хууль болон түүний хэрэгжилтийн талаар санал асуулгад хамрагдсан нийт иргэдийн 45.3 хувь нь огт мэдэхгүй, “Шилэн дансны **Shilendans.gov.mn** сайтаар зочлон мэдээлэл авч байсан уу?” гэсэн асуултад иргэдийн 76 хувь нь “үгүй” гэж хариулсан нь хуулийн талаар иргэдийн мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна.

Шилэн дансны цахим хуудаснаас санал асуулгад хамрагдсан иргэдийн 25 хувь мэдээлэл авч ашигласан, 24 хувь нь тус хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний хяналтын эрхээ мэдэж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм.



Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан иргэний хяналтыг судалгаанд хамрагдсан иргэдийн 12 хувь нь хэрэгжүүлсэн нь иргэд хуульд заасан иргэний хяналтын талаар мэдлэг муутай байна.

Иймд ТЕЗ хуулийн дагуу ил, тод байдлыг хангуулж, тус хуулийг сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулж байх шаардлагатай байна.

Төрийн аудитын байгууллага болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэдээс Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан гомдол, мэдээлэл ирүүлээгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зочилсон иргэдийн хандалтын тоог харуулах автомат цонхтой болгох саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх саналд тусган уламжилж байна. Энэ нь тус хуудсанд хандаж мэдээлэл авсан иргэдийн тоог хянах боломжийг бүрдүүлэх юм.

БҮЛЭГ 4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлжээ.

Шилэн дансны тухай хуулийн 2016 оны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар дараах 2 заалт бүхий албан шаардлагыг төсөв захирагч нар хүргүүлсэн байна. Үүнд:

- Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар төсвийн гүйцэтгэлийн 2016 оны 9, 10 дугаар сарын мэдээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэж тэмдэглэн 31.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй гэсэн албан шаардлагын хариуг Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны 1 дүгээр сарын 04-ний

өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлж, энэ удаагийн аудитаар шалгахад зөрчлийг давтан гаргаагүй ажиллажээ.

- Дундговь аймгийн Цөм сүргийн үржлийн төв 2015, 2016 онуудад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй гэж албан шаардлага хүргүүлсэн боловч тус байгууллага нь татан буугдсан тул биелэлтийг ирүүлээгүй байна.

4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх аудитаар аймаг, сумдын Засаг дарга нар, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дараах 2 зөвлөмжийг өгчээ.

1. Аймаг, сумдын Засаг дарга нарт “Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах” гэсэн зөвлөмж өгсөний дагуу ТЕЗ-ын харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн 2016 оны хэрэгжилтэд дотоод аудитыг хийж тайланг Төрийн аудитын газарт ирүүлсэн. Мөн санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2017.05.30-ны өдрийн 96 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлжээ.
2. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд “Аймаг, сумын ИТХ, иргэдийн Нийтийн Хурал хуулинд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах” гэсэн зөвлөмж өгсөн бөгөөд хариуг аймгийн ИТХТ-ын нарийн бичгийн даргын 2017.06.27-ны өдрийн 2/85 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч ИТХ-аас 2017 онд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6 /Аудитараар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй/-д заасны дагуу зөвлөмж хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлагыг хүргүүллээ.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 2015 оны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар /2016 оны 1 дүгээр улиралд илэрсэн алдаа зөрчилд/ өгсөн албан шаардлагын биелэлтийг Дундговь аймгийн Дэрэн сумын “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв” ирүүлээгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2⁸ дахь заалтын дагуу тус ОНӨААТҮГ-ын дарга /М.Сосорбурам/, нягтлан бодогч /Д.Бадамханд/ нарт хариуцлага тооцох саналыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

⁸ 28.2.2 /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

- Шилэн дансны тухай хуулийн 3.1.4 болон 3.1.5-д хамаарах байгууллагуудаас бусад байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан ажилласан байна.
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудаас шилэн дансны цахим хуудастай байгууллагууд мэдээллийг 92.4 хувьтай мэдээлсэн байна.
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн болон иргэдийн хяналт хангалтгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын зөвлөмж

Аймаг, сумдын Засаг дарга нарт

1. Зөрчлийг давтан гаргаж байгаа албан тушаалтнуудад арга хэмжээ авч, 14,549.9 сая төгрөгийн зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах;
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу мэдээллийг оруулах талаар гэрээнд тусгаж, гэрээг дүгнэхдээ мэдээлэл оруулсан байдалд хяналт тавьж ажиллах;
3. Хуулийн дагуу ил, тод байдлыг хангуулж, тус хуулийг иргэдэд сурталчилах үйл ажиллагааг зохион байгуулах;
4. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу байгууллагууд шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудас /Dundgovi.gov.mn/-д байршуулах ажлыг зохион байгуулах.

Тайлан бичсэн:

Ахлах аудитор

Д.Ихбаяр

Аудитор

Т.Оюун-Эрдэнэ

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

ҮАГ-аар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.3 /тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 1, 20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар/ дахь маягт нь Шилэн дансны тухай хуулийн 6.2.6, 6.3.2, 6.3.3, 6.3.8 дахь заалтын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээлэх хүснэгт бөгөөд дээрх маягтаас төсвийн өөрчлөлтийг харах боломжгүй байгаа тул маягтыг мэдээллийн агуулгын дагуу засч сайжруулах;
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зочилсон иргэдийн хандалтын тоог харуулах автомат цонхтой болгох;
3. Цахим хуудсанд байршуулсан маягтаарх мэдээллийг татаж авах, хэвлэх боломжгүй байна. Үүнийг цаашид засаж сайжруулах шаардлагатай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн ачаагийн үйлчилгээний 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заагдсан үйлчилгээний ачаагийн үйлчилгээний төлөөлөгчөөс тус газраас хийгдсэн ажил үйлдлийн талаар авлаа.



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,
Утас: 7059-3050, Факс: 7059-2895,
E-mail: info@dundgovi.gov.mn

2017. 11. 16 № 111121

танай _____-ны № _____-т

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлтэй холбогдсон тайланд өгөх санал тайлбар байхгүй болохыг мэдэгдэе.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



*Оюунмөнх
Оюунмөнх
953110*

0200481

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/24

Мандалговь

Нийцлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, Нийцлийн аудитын түр журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг /УАГ-НАГ/2017/03-НА/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.ТӨВСАНАА



D:\office\Alban bichig\A4\Tailan batalgaajuulah tuhai.docx

0000000037

Тайлангийн хавсралтууд

Хавсралт №1

Тогтмол мэдээлэх мэдээллүүдийг заалт тус бүрээр нь мэдээлсэн байдал

№	Тогтмол мэдээлэх мэдээлэл	Нийт мэдээлбэл зохих	Мэдээлээгүй	Хугацаа хоцорсон
1	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	176	13	31
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	176	5	50
3	ОНХС-ийн төлөвлөлт	16	3	34
4	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	2112	95	279
5	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	176	35	5
6	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	352	47	22
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	176	59	1
8	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	176	41	29
9	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.	704	84	32
10	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	322		13
11	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	322	24	16
12	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	2112		304
13	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	2112		173
14	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	176		1
15	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	1932		197
		11040	406	1187

Хавсралт №2

Долоо хоногийн дотор мэдээлэх мэдээллүүдийг заалт тус бүрээр нь мэдээлсэн байдал

№	7 хоногийн дотор мэдээлэх мэдээллүүд	Мэдээлбэл зохих	Мэдээлээгүй	Хугацаа хоцорсон
1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	2112	10	232
2	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	2112	47	205
3	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	228	104	0
4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	2120		214
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	1932		210
6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	2112	792	216
7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	1920	600	219
8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	2100	14	258
Нийт		14636	1567	1554

Хавсралт №3

Хугацаа хоцорсон байгууллагуудын жагсаалт

№	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих мэдээ болон хугацаа хоцорсон байдал						9 сарын байдлаар хугацаа хоцроосон	
		6.4 /7 хоног бүр мэдээлэх/		6.1 /Тогтмол мэдээлэх/		6.2, 6.3 /мэдээлэл хүргэх хэлбэр/			
		нийт	хоцорсон	нийт	хоцорсон	нийт	хоцорсон	нийт	хоцорсон
1	Аймгийн шүүх	84	5	23	2	41	2	148	9
2	Аймгийн прокурор	84	0	23	0	41	0	148	0
3	Стандарт, хэмжил зүйн төв	84	0	23	3	41	2	148	5
4	Онцгой байдал	84	7	23	1	41	3	148	11
5	Мэргэжлийн хяналтын газар	84	5	23	3	41	2	148	10
6	Татварын хэлтэс	84	3	23	3	41	5	148	11
7	Цагдаагийн газар	84	1	23	0	41	0	148	1
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	84	37	23	7	41	17	148	61
9	Шүүхийн шинжилгээний алба	84	3	23	5	41	5	148	13
10	Улсын бүртгэлийн хэлтэс	84	1	23	1	41	0	148	2
11	Их газрын чулууны БЦГЗ	84	8	23	3	41	4	148	15
12	УЦУОШТ	84	6	23	1	41	5	148	12
13	Боловсрол соёлын газар	84	5	23	4	41	2	148	11
14	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	84	2	23	2	41	1	148	5
15	Нийгмийн даатгалын хэлтэс	84	10	23	3	41	0	148	13
16	Хөдөө аж ахуйн газар	84	9	23	2	41	3	148	14
17	Эрүүл мэндийн газар	84	1	23	0	41	0	148	1
18	Нэгдсэн эмнэлэг	84	7	23	1	41	1	148	9

19	Уламжлалт анагаах ухааны төв	84	12	23	2	41	5	148	19
20	Зоонз	84	2	23	1	41	1	148	4
21	Аудитын газар	84	4	23	1	41	1	148	6
22	МСҮТ	84	39	23	13	41	16	148	68
23	Цэргийн анги	84	0	23	2	41	0	148	2
24	Статистикийн хэлтэс	84	20	23	8	41	3	148	31
25	Хөдөлмөр эрхлэлтийн сан	84	5	23	2	41	4	148	11
26	Нийгмийн халамжийн сан	84	38	23	10	41	19	148	67
27	Нийгмийн даатгалын сан	84	19	23	4	41	7	148	30
28	Аймгийн ТЕЗ	84	1	35	3	41	2	160	6
29	Аймгийн ЗДТГ	84	6	23	4	41	3	148	13
30	Аймгийн ИТХ	84	40	23	8	41	18	148	66
31	Санхүүгийн хяналт аудитын алба	84	7	23	1	41	3	148	11
32	Орон нутгийн өмчийн газар	84	0	23	0	41	0	148	0
33	Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	84	20	23	7	41	9	148	36
34	БТСХ	84	4	23	2	41	0	148	6
35	Номын сан	84	18	23	4	41	9	148	31
36	ТХДЖТ	84	0	23	3	41	1	148	4
37	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр	84	0	23	0	41	0	148	0
38	Музей	84	23	23	7	41	9	148	39
39	Хот тохижуулах	84	1	23	1	41	1	148	3
40	Сум дундын ойн анги	84	0	23	0	41	0	148	0
41	БОАЖГ	84	1	23	0	41	0	148	1
42	Газрын алба	84	0	23	0	41	0	148	0
43	Боржигон мандал өрхийн эмнэлэг	4	2	0	0	0	0	4	2
44	Өлзийт мандал өрхийн эмнэлэг	4	2	0	0	0	0	4	2
45	Аймгийн ТЕЗ					41	0		
46	Өлзийт ТЕЗ	60	13	24	2	41	1	125	16
47	Өлзийт сургууль	84	2	23	1	41	0	148	3
48	Өлзийт цэцэрлэг	84	1	23	1	41	0	148	2

49	Өлзийт соёлын төв	84	1	23	1	41	0	148	2
50	Өлзийт ЗДТГ	84	0	23	1	41	0	148	1
51	Өлзийт ИТХ	84	0	23	0	41	0	148	0
52	Өлзийт Эмнэлэг	84	0	23	0	41	0	148	0
53	Өлзийт ЭЭС	84	35	23	7	41	15	148	57
54	Луус ТЕЗ	60		24	10	25		109	
55	Луус ИТХ	84	0	23	0	41	0	148	0
56	Луус ЗДТГ	84	0	23	0	41	0	148	0
57	Луус Эмнэлэг	84	0	23	0	41	3	148	3
58	Луус сургууль	84	2	23	1	41	0	148	3
59	Луус цэцэрлэг	84	3	23	1	41	1	148	5
60	Луус соёлын төв	84	2	23	2	41	0	148	4
61	Луус ЭЭС	84	0	23	0	41	0	148	0
62	Хулд ТЕЗ	60	12	24	6	25	2	109	20
63	Хулд ЗДТГ	84	11	23	2	41	4	148	17
64	Хулд ИТХ	84	8	23	2	41	3	148	13
65	Хулд Эмнэлэг	84	11	23	1	41	4	148	16
66	Хулд сургууль	84	6	23	1	41	2	148	9
67	Хулд цэцэрлэг	84	8	23	1	41	3	148	12
68	Хулд соёлын төв	84	11	23	2	41	4	148	17
69	Хулд ЭЭС	84	28	23	7	41	13	148	48
70	Дэлгэрхангай ТЕЗ	60	4	24	3	25		109	
71	Дэлгэрхангай сургууль	84	7	23	2	41	12	148	21
72	Дэлгэрхангай цэцэрлэг	84	3	23	2	41	9	148	14
73	Дэлгэрхангай соёлын төв	84	14	23	2	41	22	148	38
74	Дэлгэрхангай ИТХ	84	17	23	11	41	12	148	40
75	Дэлгэрхангай Эмнэлэг	84	32	23	9	41	21	148	62
76	Дэлгэрхангай ЗДТГ	84	22	23	8	41	12	148	42
77	Дэлгэрхангай ЭЭС	84	0	23	1	41	0	148	1
78	Сайхан-Овоо ТЕЗ	60	13	24	7	25	4	109	24
79	Сайхан-Овоо сургууль	84	20	23	4	41	11	148	35
80	Сайхан-Овоо цэцэрлэг	84	17	23	5	41	7	148	29
81	Сайхан-Овоо соёлын төв	84	14	23	3	41	4	148	21

82	Сайхан-Овоо ИТХ	84	18	23	3	41	8	148	29
83	Сайхан-Овоо Эмнэлэг	84	22	23	3	41	11	148	36
84	Сайхан-Овоо ЗДТГ	84	17	23	2	41	7	148	26
85	Эрдэнэдалай ТЕЗ	60	12	24	5	25	1	109	18
86	Эрдэнэдалай сургууль	84	0	23	0	41	0	148	0
87	Эрдэнэдалай цэцэрлэг	84	1	23	1	41	0	148	2
88	Эрдэнэдалай соёлын төв	84	0	23	0	41	0	148	0
89	Эрдэнэдалай ИТХ	84	27	23	4	41	11	148	42
90	Эрдэнэдалай Эмнэлэг	84	9	23	0	41	2	148	11
91	Эрдэнэдалай ЗДТГ	84	17	23	3	41	7	148	27
92	Эрдэнэдалай Спортын төв	84	0	23	0	41	0	148	0
93	Эрдэнэдалай ЭЭС	84	14	23	2	41	6	148	22
94	Адаацаг ТЕЗ	60	4	24	9	25	7	109	20
95	Адаацаг Сургууль	84	0	23	2	41	1	148	3
96	Адаацаг цэцэрлэг	84	0	23	2	41	1	148	3
97	Адаацаг Соёлын төв	84	0	23	2	41	1	148	3
98	Адаацаг ИТХ	84	0	23	4	41	3	148	7
99	Адаацаг Эмнэлэг	84	0	23	4	41	3	148	7
100	Адаацаг ЗДТГ	84	1	23	4	41	3	148	8
101	Адаацаг ЭЭС	84	56	23	12	41	18	148	86
102	Дэлгэрцогт ТЕЗ	60	5	24	5	25	0	109	10
103	Дэлгэрцогт сургууль	84	0	23	0	41	0	148	0
104	Дэлгэрцогт цэцэрлэг	84	0	23	0	41	0	148	0
105	Дэлгэрцогт соёлын төв	84	0	23	1	41	0	148	1
106	Дэлгэрцогт ИТХ	84	1	23	3	41	2	148	6
107	Дэлгэрцогт Эмнэлэг	84	1	23	4	41	1	148	6
108	Дэлгэрцогт ЗДТГ	84	2	23	6	41	4	148	12
109	Дэлгэрцогт ЭЭС	84	34	23	3	41	12	148	49
110	Дэрэн ТЕЗ	60	0	24	1	25	1	109	2

111	Дэрэн сургууль	84	0	23	0	41	0	148	0
112	Дэрэн цэцэрлэг	84	2	23	0	41	0	148	2
113	Дэрэн соёлын төв	84	0	23	2	41	1	148	3
114	Дэрэн ИТХ	84	1	23	2	41	1	148	4
115	Дэрэн Эмнэлэг	84	2	23	2	41	1	148	5
116	Дэрэн ЗДТГ	84	1	23	1	41	0	148	2
117	Дэрэн ээс	84	14	23	3	41	5	148	22
118	Цагаандэлгэр ТЕЗ	60	12	24	0	25	0	109	12
119	Цагаандэлгэр сургууль	84	15	23	5	41	7	148	27
120	Цагаандэлгэр цэцэрлэг	84	15	23	5	41	7	148	27
121	Цагаандэлгэр соёлын төв	84	15	23	5	41	7	148	27
122	Цагаандэлгэр ИТХ	84	2	23	4	41	2	148	8
123	Цагаандэлгэр Эмнэлэг	84	3	23	6	41	3	148	12
124	Цагаандэлгэр ЗДТГ	84	2	23	6	41	2	148	10
125	Цагаандэлгэр ЭЭС	84	53	23	7	41	21	148	81
126	Баянжаргалан ТЕЗ	60	5	24	7	25	4	109	16
127	Баянжаргалан Сургууль	84	14	23	2	41	6	148	22
128	Баянжаргалан цэцэрлэг	84	14	23	4	41	8	148	26
129	Баянжаргалан соёлын төв	84	14	23	4	41	6	148	24
130	Баянжаргалан ИТХ	84	0	23	2	41	1	148	3
131	Баянжаргалан Эмнэлэг	84	1	23	2	41	3	148	6
132	Баянжаргалан ЗДТГ	84	0	23	0	41	0	148	0
133	Баянжаргалан ЭЭС	84	26	23	4	41	7	148	37
134	Говь-Угтаал ТЕЗ	60	0	24	0	25	0	109	0
135	Говь-Угтаал сургууль	84	9	23	3	41	2	148	14
136	Говь-Угтаал цэцэрлэг	84	3	23	4	41	0	148	7
137	Говь-Угтаал соёлын төв	84	4	23	3	41	0	148	7
138	Говь-Угтаал ИТХ	84	4	23	0	41	1	148	5

139	Говь-Угтаал Эмнэлэг	84	3	23	3	41	2	148	8
140	Говь-Угтаал ЗДТГ	84	2	23	1	41	0	148	3
141	Говь-Угтаал ЭЭС	84	12	23	3	41	4	148	19
142	Өндөршил ТЕЗ	60	2	24	1	25	1	109	4
143	Өндөршил сургууль	84	4	23	1	41	6	148	11
144	Өндөршил цэцэрлэг	84	0	23	0	41	1	148	1
145	Өндөршил соёлын төв	84	1	23	2	41	1	148	4
146	Өндөршил ИТХ	84	15	23	2	41	6	148	23
147	Өндөршил Эмнэлэг	84	14	23	2	41	6	148	22
148	Өндөршил ЗДТГ	84	3	23	2	41	4	148	9
149	Өндөршил ЭЭС	84	0	23	1	41	1	148	2
150	Гурвансайхан ТЕЗ	60	2	24	10	25	1	109	13
151	Гурвансайхан сургууль	84	15	23	4	41	7	148	26
152	Гурвансайхан цэцэрлэг	84	7	23	2	41	2	148	11
153	Гурвансайхан соёлын төв	84	17	23	2	41	10	148	29
154	Гурвансайхан ИТХ	84	15	23	2	41	6	148	23
155	Гурвансайхан Эмнэлэг	84	14	23	2	41	6	148	22
156	Гурвансайхан ЗДТГ	84	20	23	2	41	8	148	30
157	Гурвансайхан ЭЭС	84	50	23	1	41	15	148	66
158	СЦ ТЕЗ	60	3	24	3	25	1	109	7
159	СЦ ИТХ	84	0	23	0	41	0	148	0
160	СЦ ЗДТГ	84	3	23	0	41	2	148	5
161	СЦ Эмнэлэг	84	0	23	0	41	0	148	0
162	СЦ 1 сургууль	84	1	23	0	41	0	148	1
163	СЦ Говийн ирээдүй цогцолбор сургууль	84	0	23	0	41	0	148	0
164	СЦ 3 сургууль	84	0	23	0	41	0	148	0
165	СЦ 4 Сургууль	84	0	23	0	41	0	148	0
166	СЦ Мандал сургууль	84	0	23	0	41	0	148	0
167	СЦ 1 цэцэрлэг	84	2	23	0	41	2	148	4
168	СЦ 2 цэцэрлэг	84	0	23	0	41	0	148	0

169	СЦ 3 цэцэрлэг	84	0	23	1	41	0	148	1
170	СЦ4 цэцэрлэг	84	0	23	1	41	0	148	1
171	СЦ 5 цэцэрлэг	84	0	23	0	41	0	148	0
172	СЦ 6 цэцэрлэг	84	4	23	0	41	2	148	6
173	СЦ 7 цэцэрлэг	84	1	23	2	41	2	148	5
174	СЦ ЭЭС	84	24	23	8	25	12	132	44
175	Дундговь-Ус	84	32	23	6	41	12	148	50
176	Дэрэн сум Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээний төв	84	31	23	12	41	12	148	55
177	Нийтлэг үйлчилгээ	84	33	23	0	41	9	148	42
178	Нисэх буудал	84	57	23	12	41	24	148	93
179	Авто тээврийн үндэсний төв	84	0	23	0	41	0	148	0
Нийт		14432	1550	4075	486	7017	702	25483	2721